

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавартай нийт 80 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.** Амжилт хүсье.

- Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой.
..... гэдэг нь ижил төстэй шинж бүхий хүм амын статистик нэгдэл. /1 оноо/
А. Нийгмийн давхраажилт В. Нийгмийн ялгарал С. Нийгмийн давхраа
D. Тэгш бус байдал E. Нийгмийн нийтлэг
- Дараах ойлголтоос аль нь алагчлалыг тодорхойлсон байна вэ? /1 оноо/
А. Тодорхой хэв шинжит харилцаа бүхий тэгш бус байдлын тогтолцооны ойлголт
В. Эрэгтэй эмэгтэй хүний биологийн буюу бие махбодийн ялгаа, заяагдмал шинжтэй
С. Эдийн засгийн баялаг, нэр хүнд, эрх мэдэлд хүрэх адил бус боломж бүхий байдал
D. Нэг бүлэгт давуу боломж олгосон атлаа нөгөөгийнх нь боломжийг хааж буй үйлдэл
E. Хүний нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийг тодорхойлж байдаг
- Дараах ойлголтуудын аль нь бүтэц-чиг үүргийн онолд хамаарах вэ? /2 оноо/
А. Ашиг сонирхлоо хэрэгжүүлж чадах эсэх нь эрх мэдэлд хүрч байгаагаас хамаардаг
В. Анги бол үйлдвэрлэлийн хэрэгсэлтэй харилцах харилцаагаараа ялгаатай бүлэг
С. Нэг хэсэг байр суурь нь бусдаас илүү чухал бөгөөд илүү өндөр ур чадварыг шаарддаг
D. Баялгийг шинээр олж авсан баяныг бус, ядуурч хоосорсон язгууртныг хүндэтгэдэг
E. Нам нь ашиг сонирхлоороо ялгаатай хүмүүс бөгөөд эрх мэдлийн ялгарлыг илтгэнэ
- Манжийн эрхшээлийн үеийн монголын нийгмийн давхраажилтыг хамаарах бүтэцтэй нь тохируулна уу. /2 оноо/

a	Дээд давхраа	1	Засаг ноёдоос хамгийн олон нь алтан ургийн ноёд байсан.
b	Дунд давхраа	2	Өмч хөрөнгө, эрх мэдэлгүй гэрийн боолууд
c	Доод давхраа	3	Ноёдод татвар нийлүүлж, мал сүргийг нь адгуулах үүрэгтэй.

- A. a1, b2, c3 B. a1, b3, c2 C. a3, b1, c2 D. a3, b2, c1 E. a2, b1, c3
- 5 настай нэгэн охиныг ноорхой хувцас өмсгөж, нөгөө охиныг үнэтэй брэндийн хувцас өмсгөн дэлгүүрийн үүдэнд зогсоон “ утсаараа яриулаач” гэж хүмүүсээс тусламж хүсэхэд алинд нь илүү анхаарал хандуулж байгааг судлах, хамаарлыг нь илрүүлэхээр зохиомол орчин бүрдүүлэх замаар судалгаа хийсэн гэж үзвэл аль аргад хамаарах вэ? /1 оноо/
А. Ажиглалт В. Туршилт С. Фокус ярилцлага
D. Асуулга E. Контент анализ



6. Дараах бодомжуудаас марксизм (шүүмжлэлт онол) онолыг нийгмийн судалгааны үүднээс тайлбарласныг олоорой. /1 оноо/
- A. Нийгэм нь хувь хүний хүсэл зоригоос үл хамаарах объектив мөн чанартай тул нийгмийн судалгаагаар нийгмийн бодит байдал дахь үзэгдэл хоорондын зүй тогтлыг илрүүлж чадна.
- B. Нийгмийн бодит байдлыг судлах нь хүмүүс хэрхэн харилцдаг, тэдгээр хүмүүсийн үйлдэлд илрэх утга учрыг тэдний нүдээр харж, ойлгох явдал гэж үзнэ.
- C. Эрх мэдэлтэй хийгээд эрх мэдэл багатай хүмүүсийн харилцааны цаана оршин буй нийгмийн бодит байдлыг илрүүлэн өөрчлөх, сайжруулах боломжийг хайхаар нийгмийн судалгааг хийдэг гэж үздэг.
- D. Мэдлэгийг бүтээхдээ байгаль судлаачдын адилаар дедукцийн аргын дагуу объективоор судлан онол бүтээх боломжтой гэж үздэг.
- E. Нийгмийн тухай ерөнхий онол гэж байх боломжгүй бөгөөд судлагдсан бодит байдлаар индукцийн аргын дагуу тодорхой түвшний онол бүтээх боломжтой гэж үздэг.
7. Нийгмийн судалгааны асуулгын арга нь 5 хэсэгтэй. Үүнээс ерөнхий мэдээллийн хэсэгт хамаарах өгөгдөл аль нь вэ? /1 оноо/
- A. Судалгаанд баримталж буй ёс зүйн хэм хэмжээний тухай байна.
- B. Судалгаанд байгаа асуултад хэрхэн хариулах заавар байна.
- C. Туслах асуултын залгамж чанар, логик, уялдааг анхаарсан байна.
- D. Хувь хүний нийгмийн байр суурийг тодруулах асуултууд байна.
- E. Талархал, холбоо барих утас, хаяг зэргийн талаар мэдээлэл байна.
8. Хүснэгтэд байгаа тулгуур ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /2 оноо/

a	Түүвэр судалгаа	1	Эх олонлогоос судалгаанд сонгон хамруулах олонлог
b	Түүвэр олонлог	2	Эх олонлогийг бүхэлд нь бус дэд хэсгийг хамруулах судалгаа
c	Санамсаргүй түүврийн арга	3	Эх олонлогийн бүх гишүүд судалгаанд хамрагдах адил магадлалтай байх

- A. a2, b1, c3 B. a1, b2, c3 C. a2, b3, c1 D. a3, b2, c1 E. a1, b3, c2

9. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой.
Нийгмийн амьдралд үндсэн эргэлт гаргадаг зэвсэгт бослого, төрийн эргэлт зэрэг харьцангуй хурдтай, чанарын гүнзгий өөрчлөлтийг гэнэ. /1 оноо/
- A. Нийгмийн хувьсгал B. Нийгмийн гажуудал C. Нийгмийн хувьсал
D. Нийгмийн шинэтгэл E. Нийгмийн шинэчлэл
10. “Эдийн засгийн амьдрал бол нийгмийн өөрчлөлтийн суурь, түүнийг дагаж давхаргын шинжтэй улс төр, шашин зэрэгт өөрчлөлт гардаг” гэдэг нь хэний үзэл баримтлал вэ? /1 оноо/
- A. Тённис B. М. Вебер C. Г. Ленский D. Т. Билтон E. К. Маркс
11. “Зөгий, шоргоолжны эд эсэнд нь шингэсэн үйлдэл хийх чадвар байдаг шиг хүнд төрөлхөөс заяадаггүй, ахмад үеэсээ залуу үе нь зориуд сурч мэдэж өвлөх ёстой үйлдэл хийх чадвар байдгийг соёл гэж тэмдэглэдэг”. Энэ хэний үзэл баримтлал вэ? /1 оноо/
- A. Э.Кассирер B. А.Гидденс C. Э.Тайлор D. Р.Бенедикт E. Ж.Локк



12. Хүснэгтэд байгаа тулгуур ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /2 оноо/

a	Монгол хэлний тухай хууль	1	Соёлын үнэт зүйл гэдэгт бичиг үсэг, бэлгэ тэмдэг хамаарна.
b	МУ-ын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль	2	Идэвх санаачилга гаргасан иргэн, хуулийн этгээдэд 4 жил тутамд нэрэмжит шагнал олгох тухай заасан.
c	МУ-ын Соёлын тухай хууль	3	Монголын түүх, соёл бол үндэсний аюулгүй байдлын дархлаа мөн

A. a2, b1, c3 B. a1, b2, c3 C. a2, b3, c1 D. a3, b2, c1 E. a1, b3, c2

13. “Монгол соёлыг нэгтгэгч язгуур үнэлэмжид монгол аж төрөх ёс, ардын урлаг, ёс заншил, бусад үндэстнээс ялгарсан өвөрмөц төрхтэй” гэсэн нь соёлын аль ойлголтыг илэрхийлж байна вэ? /1 оноо/

A. Түгээмэл шинж B. Нэгдмэл шинж C. Соёлын статик
D. Соёлын даяаршил E. Соёлын хэлбэр

14. Хүснэгт дэх мэдээллийг уншаад соёлыг хэн бүтээж байна вэ? гэдгээс хамаарч ангилсан хэсгийг сонгоорой /1 оноо/

A	Үндэсний соёлыг ангилал гол шалгуур нь зонхилогч ба дэд соёл болно.
B	Хадны зураг, археологийн дурсгал, морин хуур, уртын дуу, бие биелгээ нь биет ба биет бус соёлд хамаарна.
C	Уртын дуу, дуурь, нийтийн дуу нь тус бүр соёлын ардын, нийтийн, сонгодог гэсэн ангилалд хамаарна.
D	Соёл нь ан агнуур, түүвэрлэгчдийн, нүүдэлчдийн гэх мэт аж ахуйн хувьд ялгаатай оршдог.
E	Хүмүүсийн амьдралын хэв маягт онцлог ялгаатай соёл бүрэлдэх нь олон хэв загварын соёлд хамаарна.


15. Соёлын үйлдвэрлэл үндэсний хөтөлбөрийг соёлын үйлдвэрлэл үйлчилгээ явуулах боломж, нийгэм, эдийн засгийн үр ашгийг харгалзан үзэж тодорхой хүрээнд хэрэгжүүлэхээр заасан байдаг. Үүнд хамаарах хүрээг ялгана уу. /1 оноо/

1. Дизайн, дүрслэх урлаг 2. Дэвшилтэд технологи 3. Шинжлэх ухаан
4. Соёлын аялал жуулчлал 5. Соёлын шок

A. 4, 5 B. 1, 4 C. 2, 3 D. 2, 4 E. 3, 4



16. Дараах бүдүүвчийг ажиглаад соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд баримтлах зарчмуудыг гүйцээгээрэй. /2 оноо/




- A. Тухайн соёлын бусдаас ялгарах, дахин давтагдашгүй өвөрмөц шинжийг нээх
- B. Эрх чөлөө, ардчилал, хүлээцтэй байдал, шударга ёсны үнэ цэнийг дэлгэрүүлэх
- C. Дэлхийд өөрсдийн брэндийг бий болгож, шударга өрсөлдөөнийг дэмжих
- D. Байгалийн болон соёлын өвийн газруудтай харилцан шүтэлцээтэй хөгжүүлэх
- E. ДНБ-ийн хэмжээг нэмэгдүүлэн ард түмний амьжиргааг дээшлүүлэх

17. “Хүнийг өдөр бүр телевизийн дэлгэц болон дэлхийн цахим сүлжээний шүүлтүүр муутай мэдээллээр угжаад байвал хүний, түүний эргэн тойрныхны мэдлэг туршлага, үнэт зүйл алдагдах нь илэрхий” гэсэн мэдээлэл нь дараах ойлголтоос алийг түлхүү илэрхийлж байна вэ? /1 оноо/

- A. Соёлын дархлаа сулрах шалтгаан
- B. Соёлоо хадгалж үлдэх шалтгаан
- C. Соёлоо эрхэмлэхийн шалтгаан
- D. Соёлын суурь зарчмын шалтгаан
- E. Соёлын зөрчих хандлагын шалтгаан

18. Дараах бүдүүвчийг ажиглаад соёлын харилцан үйлчлэлийн хэлбэрийг гүйцээгээрэй. /2 оноо/



- A. Соёлыг тулгалт
- B. Соёлын цочирдол
- C. Соёлын солилцоо
- D. Соёлын эрх чөлөө
- E. Соёлыг хуулбарлан дуурайх

19. Дараах эрдэмтдийг тохирох үзэл баримтлалтай нь харгалзуулна уу. /2 оноо/

a	Ж. Локк	1	Кибернетикийн хувьсгал, цөмийн зэвсэглэл нь нийгмийн зан чанарыг хүнлэг бус болгож байна.
b	Дж.Кэмпбелл	2	Хүнд амьдрах эрх, эрх чөлөөтэй байх, өмчлөх эрх гэсэн 3 эрх төрөлхөөс заяадаг.
c	Э. Фромм	3	Эрх чөлөөтэй байх эсэх нь хувь хүнээс өөрөөс нь шалтгаална.

- A. a3, b2, c1
- B. a1, b2, c3
- C. a2, b1, c3
- D. a2, b3, c1
- E. a1, b3, c2



20. Тухайн улсын хэмжээнд жилийн турш үйлдвэрлэсэн баялгийг орлогын нийлбэр дүнгээр ДНБ-ийг тодорхойлох аргыг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
А. ДНБ-ийг тогтмол үнээр тооцох
В. ДНБ-ийг өнөөгийн үнээр тооцох
С. ДНБ-ийг орлогоор тооцох
D. ДНБ-ийг зардлаар тооцох
E. Нэг хүнд ногдох ДНБ-ийг тооцох
21. Нийгэм, эдийн засгийн үзэгдэлд өсөлтийн хурдыг хувиар тооцоолоход үзүүлэлт нь 100-аас бага утгатай бол ямар утгыг харуулах вэ? /1 оноо/
А. Өсөлт, бууралт байхгүй
В. 2 дахин хурдтай өссөн
С. 2 дахин хурдтай буурсан
D. Өссөн утгыг илэрхийлнэ
E. Буурсан утгыг илэрхийлнэ
22. Дараах өгөгдлүүдийн аль нь төсвийн бодлогын нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгод хамаарах вэ? /1 оноо/
А. Зээлийн хүүг бууруулж, гүйлгээнд байгаа мөнгийг өсгөх
В. Засгийн газар бонд гаргаж худалдах, худалдан авах
С. Зээлийн хүүг өсгөж, гүйлгээнд байгаа мөнгийг бууруулах
D. Хувь хүн болон ААН-ээс авах татварын хэмжээг бууруулах
E. Эдийн засгийн уналтыг сааруулах, инфляцийг бууруулах
23. 2023 онд Монгол улсын экспорт нь 490 тэрбум төгрөг, импорт нь 330 тэрбум төгрөг байсан бол тус оны МУ-ын гадаад худалдааны нийт эргэлтийг тооцоолно уу. /1 оноо/
А. 820 В. -160 С. 160 D. - 820 E. 410
24. Дараах эдийн засгийн ойлголтоос аль нь Д.Кейнсийн үзэл баримтлал вэ? /2 оноо/
А. Эдийн засаг дахь төрийн идэвхтэй оролцоо нь түүнд зөвхөн хор учруулна.
В. Гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ болон үнийн түвшин нь шууд хамааралгүй.
С. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалсан.
D. Эдийн засагт төрийн оролцоо нь нийт эрэлтийг нэмэгдүүлэх гол арга зам гэж үзсэн.
E. Эдийн засгийн салбарт оруулсан хувь нэмрийг үнэлэн Нобелийн шагнал олгосон.
25. Инфляцийн нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөлд үл хамаарахыг олно уу. /1 оноо/
А. Бараа, үйлчилгээний нийт эрэлт буурна
В. Хүн амын орлого буурна
С. Бараа, бүтээгдэхүүний үнэ буурна
D. Үнэт цаас, хадгаламж, зээл үнэгүйднэ
E. Эдийн засгийн дотоод тэнцвэрийг алдагдуулна
26. Хөдөлмөрийн зах зээлд цалингийн түвшин 300 мянган төгрөг болж өсөхөд хөдөлмөрийн нийлүүлэлт 200 нэгж байсан. Тэгвэл хөдөлмөрийн эрэлт 400 нэгж байхад ямар үзэгдэл бий болох вэ? /2 оноо/
А. Ажилах хүчний илүүдэл бий болно (200 нэгжээр өснө)
В. Ажиллах хүчний хомсдол бий болно (200 нэгжээр буурсан)
С. Ажиллах хүчний хомсдол бий болно (300 нэгжээр буурсан)
D. Ажиллах хүчний илүүдэл бий болно (300 нэгжээр өснө)
E. Ажиллах хүчний илүүдэл бий болно (600 нэгжээр өссөн)



27. Дараах мэдээллийг уншаад, өгөгдсөн томъёоны дагуу тооцоолоорой /2 оноо/
Монгол улсын эдийн засаг 2021 онд 25 тэрбум байсан бол, 2022 онд 25.5 тэрбум болсон гэж үзвэл 2022 онд МУ-ын эдийн засаг хэдэн хувиар өссөн бэ?

$$\text{ЭЗӨ} = \frac{\text{ДНБ тайлан} - \text{ДНБ суурь}}{\text{ДНБ суурь}} \times 100\%$$

- A. 0.5% B. -2% C. 2% D. -0.5% E. 25.3%
28. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
Улс төрийн намууд, нийгмийн бүлгүүдийн хооронд үзэл бодол, байр суурийн ялгааг нэгтгэх арга зам нь юм.
- A. Шударга байх зарчим B. Хууль дээдлэх зарчим C. Нээлттэй зарчим
D. Зөвшилцлийн зарчим E. Цөөнхийг хүндэтгэх зарчим
29. Нутгийн өөрөө удирдах байгууллагыг харуулсан бүдүүвчийг ажиглаад алдаатай хэсгийн дугаарыг сонгоно уу. /2 оноо/

1.Орон нутгийн агентлаг	•Аймаг, нийслэлийн намын төв хороо
2.Иргэдийн төлөөлөгчдийн хурал	•Сум, дүүргийн засаг дарга
3.Иргэдийн нийтийн хурал	•Баг, хорооны засаг дарга

- A. 1, 2 B. 3 C. 2 D. 2, 3 E. 1
30. Дараах өгөгдлөөс иргэний улс төр дэх хууль ёсны бус оролцоог ялгана уу. /1 оноо/

1. Сонгуульд санал өгөх	2. Улс төрийн шийдвэрийг дагахаас татгалзах
3. Эсэргүүцлийн жагсаалд оролцох	4. Нийгэм, улс төрийн амьдралд оролцох

- A. 2, 3 B. 1, 2 C. 2, 4 D. 1, 4 E. 1, 3
31. Сонгуулийн тогтолцоог тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /2 оноо/

a	Мажоритари тогтолцоо	1	Мажоритари болон пропорциональ тогтолцооны аль алиных нь онцлог шинжийг хадгалсан тогтолцоо
b	Пропорциональ тогтолцоо	2	Өрсөлдөгчөөсөө илүү санал авсан нь ялдаг тогтолцоо
c	Холимог тогтолцоо	3	Намын нэрээр санал хурааж авсан саналд нь хувь тэнцүүлж суудал хуваарилдаг тогтолцоо

- A. a1,b2,c3 B. a2,b1,c3 C. a1,b3,c2 D. a2,b3,c1 E. a3,b1,c2
32. Улс төр судлаач Г.Алмондын тодорхойлсон улс төрийн системийн оролтын чиг үүрэгт хамаарах өгөгдлийг олно уу. /2 оноо/
- A. Хууль зүйн хэм хэмжээ, шийдвэр боловсруулах
B. Хэм хэмжээ шийдвэрийг хэрэгжүүлэх
C. Улс төрийн нийгэмшилтийг хангах
D. Хэм хэмжээг хэрхэн дагаж мөрдөж буйг хянах
E. Улс төрийн нам сонгуулиар дамжин төрийн эрх барих



33. Дараах өгөгдлөөс намын нийгэмд гүйцэтгэх үүргийг ялгаарай. /2 оноо/

1. Улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх
2. Засгийн эрхийг авахын төлөө өрсөлдөх
3. Төрийн санхүүжилтыг багасгах, хасах
4. Бодлогын хэрэгжилтийг тайлагнах, хариуцлага хүлээх

A. 1,3

B. 1, 4

C. 2,4

D. 1, 2

E. 2, 3

34. Чиний бодлоор дараах ойлголт нь ардчиллын аль үнэт зүйлийг зөрчсөн байна вэ? /2 оноо/

Ардчилсан нийгэм нь иргэдийг боловсролтой болгохоос илүү ажилтай байлгахад анхаардаг бөгөөд ажилтай иргэд нь эдийн засгийг хөгжүүлэх гол хөшүүрэг юм.

A. Тэгш эрх

B. Нийтэд тайлагнах, ил тод байх ёс

C. Хуулийн засаглал

D. Боловсрол

E. Иргэдийн улс төрийн оролцоо

35. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/

..... гэдэг нь улс орны хөгжлийн бодлогыг хамтын зарчмаар тодорхойлж, хэрэгжүүлж, улс төрийн хамтын хариуцлага хүлээлгэх чадвартай иргэдийн эвлэлдэн нэгдсэн байгууллага юм.

A. Лобби бүлэг

B. Иргэний нийгэм

C. Төр

D. Сонирхолын бүлэг

E. Улс төрийн нам

36. Сонирхлын бүлгийн үйл ажиллагаа нь түүний чиг үүргээр илэрдэг. Нийгэм дэх явцуу олон шаардлагыг цэгцлэн, нэгтгэн боловсруулах нь аль чиг үүрэгт хамаарах вэ? /1 оноо/

A. Агрегаци

B. Артикуляци

C. Интеграци

D. Интервенц

E. Девальваци

37. Дараах ойлголтуудын аль нь Монгол улсын гадаад бодлогын үндэсний эрх ашигт нийцсэн байх зарчмыг илэрхийлж байна вэ? /1 оноо/

A. Үндэсний язгуур ашиг сонирхлыг сахин хамгаалсан, хөгжлийг хэрэгжүүлэх

B. Стратегийн зорилт, ач холбогдолтой улсуудын сонирхлыг тэнцвэржүүлэх

C. Гадаад харилцаандаа нөөц бололцоог бүрэн дайчлах, зохион байгуулах

D. Олон улс гүрэнтэй хамтран ажиллах, харилцааг олон хэлбэрээр явуулах

E. Хөгжиж байгаа орнуудтай нийтлэг зорилгын үүднээс хамтран ажиллах

38. “Нийгмийн гишүүн бүрийн амь бие, эд хөрөнгийг нийтийн хүчээр сахин хамгаалах чадвартай нийгмийн холбооны хэлбэрийг олох хэрэгтэй бөгөөд гишүүн бүр энэ нэгдэлд нэгдэх ёстой” гэх үзлээрээ хүний эрх, эрх чөлөөг төрийн хүчнээс хамгаалах тухай илэрхийлсэн сэтгэгч хэн бэ? /1 оноо/

A. Ж.Локк

B. Т.Гоббс

C. Л.Актон

D. Ж. Руссо

E. Р.Нозик

39. Шударга, энэрэнгүй, хүнлэг, тэгш, бусдын эрх ашгийг зөрчихгүй байх нь аль ёсны үзэл баримтлалд хамаарах вэ? /1 оноо/

A. Үндсэн хуульт ёс

B. Иргэний эрх зүйд захирагдах ёс

C. Эрх зүйд захирагдах ёс

D. Захиргааны эрх зүйд захирагдах ёс

E. Төрийн албаны эрх зүйд захирагдах ёс



40. Хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэлд хамаарах жишээг олоорой. /2 оноо/
 А. Иргэн А нь ажлаа шалтгаангүйгээр тасалсан энэ нь анхны тохиолдол
 В. Иргэн М нь албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон
 С. Иргэн С нь сахилгын зөрчил гаргаж сануулах шийтгэл авсан
 D. Иргэн Т нь сахилгын зөрчил гаргаж цалингийн 20% аар шийтгүүлсэн
 E. Иргэн Д нь ээлжийн амралтаа авсан (48 хоног амарсан)
41. Сахилгын зөрчлийн үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэлийг хэдэн сарын дотор ноогдуулах ёстой вэ? /2 оноо/
 А. Зөрчил гаргаснаас хойш 5 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс 2 сарын дотор
 В. Зөрчил гаргаснаас хойш 4 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс 2 сарын дотор
 С. Зөрчил гаргаснаас хойш 6 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс 1 сарын дотор
 D. Зөрчил гаргаснаас хойш 2 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс 3 сарын дотор
 E. Зөрчил гаргаснаас хойш 7 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс 1 сарын дотор
42. Хүснэгт дэх өмчлөх эрхтэй холбоотой ойлголтуудыг ажиглаад 1, 2 хэсгийг харьцуулаад, аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг тодорхойлоорой. /2 оноо/

Хэсэг	А. Өмчлөх эрх үүсэх үндэслэл	Б. Өмчлөх эрхээ хэрхэн хамгаалах вэ?	В. Өмчлөх эрхийн эсрэг чиглэсэн үйлдэл
1-р хэсэг	Эд хөрөнгийг дайчлан авах нь хуульд заасан үндэслэл болно.	Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргана.	Мал хулгайлах, дээрэмдэх
2-р хэсэг	Шүүхийн шийдвэрийн дагуу эд хөрөнгөтэй болох нь гэрээнд заасан үндэслэл болно.	Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргана.	Хөрөнгө завших, бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх

- А. 2-р хэсгийн Б
 В. 1-р хэсгийн В
 С. 1-р хэсгийн А
 D. 2-р хэсгийн А
 E. 2-р хэсгийн В

43. Дорж 15 настай бөгөөд хөдөлмөрийн гэрээний нэг талаар оролцож болох уу? /2 оноо/
 А. Дорж өөрийн хүсэлтээр ажил эрхлэх сонирхолтой бол хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.
 В. Дорж нь 15 настай тул иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай гэсэн үндэслэлээр хөдөлмөрийн гэрээний нэг талаар оролцох боломжгүй.
 С. Дорж нь эцэг эх, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгөөр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.
 D. Дорж нь 15 настай тул иргэний эрх зүйн заримдаг чадамжтай гэсэн үндэслэлээр хөдөлмөрийн гэрээний нэг талаар оролцох боломжгүй.
 E. Монгол улсын иргэн бүр өөрийн хүсэлтээр насны хязгаарлалтгүй ажил эрхлэх боломжтой.



44. Хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээг хэрхэн тооцдог вэ? /1 оноо/
- A. Тухайн даатгуулагчид тогтоогдвол зохих сарын тэтгэврийг шимтгэл төлбөл зохих нийт сарын тоонд үржүүлж шимтгэл төлсөн нийт сарын тоогоор хувааж тооцно.
 - B. Тухайн даатгуулагчид тогтоогдвол зохих сарын тэтгэврийг шимтгэл төлбөл зохих нийт сарын тоонд хувааж шимтгэл төлсөн нийт сарын тоогоор үржүүлж тооцно.
 - C. Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сарын дундаж хөдөлмөрийн хөлсний 45 хувиар тооцно.
 - D. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч буюу төрийн албан хаагчид сүүлийн 12 сарын цалингийн дунджийн 100 хувиар тооцно.
 - E. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байхаар тооцно.

45. Иргэнд захиргааны байгууллага мэдээлэл өгөхөөс татгалзвал 2 үе шатаар шийдвэрлүүлэх эрхтэй. 2-р үе шатад иргэн байгууллагатай харилцах аль хэлбэр хамаарахыг сонгоорой /2 оноо/

1-р шат

Дээд албан тушаалтанд нь хандан амаар болон бичгээр гомдол гаргах

2-р шат

.....

- A. Захиргааны албан тушаалтанд хүсэлт гаргах
- B. Захиргааны байгууллагад гомдол гаргах
- C. Захиргааны албан тушаалтанд гомдол гаргах
- D. Захиргааны хэргийн шүүхэд хандах
- E. Захиргааны байгууллагад хүсэлт гаргах

46. Гэмт хэргийн бус зөрчилд хамаарах ойлголт аль нь вэ? /1 оноо/
- A. Нийгэмд хор аюултай, хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай, гэм буруутай үйлдэл, эс үйлдлийг хэлнэ
 - B. Нийгэмд хор аюултай, хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай, эрүүгийн хуульд заасан гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдлийг хэлнэ
 - C. Нийгэм, нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлттэй үл нийцэх төлвийг хэлнэ.
 - D. Нийгмийн хуульчлан тогтоосон хэм хэмжээг ноцтойгоор зөрчиж бусдад гэм хор, хор хохирол учруулсан үйлдэл, эс үйлдэл хамаарна.
 - E. Захиргааны, эд хөрөнгийн, сахилгын зөрчил гаргасан гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдэл хамаарна.

47. Үндсэн хуулийн цэц эрх зүйн ямар акт гаргадаг вэ? /1 оноо/
- A. Шийдвэр
 - B. Захирамж
 - C. Тушаал
 - D. Тогтоол
 - E. Зарлиг

48. Цэгийн оронд тохирох оныг сонгоорой. /1 оноо/
- Монгол улс бүрэн улсын хувьд олон улсын эрх зүйн хүрээнд оноос Де-юре улс байх статустай болсон.


- A. 1961 он
- B. 1945 он
- C. 1948 он
- D. 1989 он
- E. 1990 он



49. Олон улсын харилцааны улс оролцогчдыг дотор нь их гүрэн, дунд улс, бага улс хэмээн ангилдаг. Дунд улсыг илэрхийлсэн тодорхойлолтыг сонгоорой. /1 оноо/
- A. Өөрийн аюулгүй байдлыг төдийгүй хөрш, холбоотон улсуудын аюулгүй байдлыг хангах чадалтай байдаг.
 - B. Өөрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэрэгсэлтэй байдагч олон улсын харилцааны хамгийн чухал оролцогчид
 - C. Олон улсын харилцаанд нөлөө багатай ч дэлхий улсуудын 2/3 нь энэ ангилалд багтдаг. Эдгээр улсгүйгээр олон улсын харилцаа өрнөх боломжгүй.
 - D. Хөгжиж байгаа болон буурай эдийн засгийн хөгжилтэй, түүхий эд, гадаад хөрөнгө оруулалт, зээл тусламжаас эдийн засаг нь ихээхэн хамааралтай
 - E. Өөрийн ойрын хүрээлэлдээ ялангуяа хөрш улсууд, бүс нутагтаа баттай нөлөөлдөг, голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсууд байдаг.


50. Дараах өгөгдлүүдээс аль нь Монгол улсын олон талт харилцаа, оролцооны үйл ажиллагаа вэ? /1 оноо/
- A. Гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээний улс орнуудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагаа.
 - B. Ази номхон далайн бүс нутгийн олон талт үйл явц, яриа хэлэлцээр интеграцид үр ашигтай оролцох явдал.
 - C. Зүүн хойт Ази, Төв Азийн олон талт үйл явц, яриа хэлэлцээр интеграцид үр ашигтай оролцох явдал.
 - D. Олон улсын хамтын нийгэмлэгийн хүрээнд явуулах бодлого, олон талт харилцаа, түншлэл, дипломат үйл ажиллагаа.
 - E. Монгол улсын хувьд нөөц бололцоог бүрэн дайчлах, зохион байгуулах үйл ажиллагаа

51. Монгол улстай түншлэлийн харилцаатай улсуудыг харуулсан бүдүүвчийг гүйцээгээрэй. /2 оноо/



- A. a-Иж бүрэн стратегийн түншлэл, b-Австрали
- B. a-Иж бүрэн стратегийн түншлэл, b-БНХАУ
- C. a-Өргөн хүрээтэй түншлэл- b-Канад
- D. a-Стратегийн түншлэл, b-Япон
- E. a-Иж бүрэн түншлэл, b-Герман

52. Гуравдагч хөрш орнуудтай дипломат харилцаа тогтоосон оныг буурах эрэмбэд оруулна уу. /2 оноо/



- A. 1, 4, 2, 3
- B. 1, 4, 3, 2
- C. 4, 1, 2, 3
- D. 2, 3, 1, 4
- E. 4, 3, 1, 2


53. Олон улсын харилцааны тоглогчид нь бүрэн эрхт улс, тэдгээрийн холбоо эвсэл байна гэж үздэг онолыг нэрлэнэ үү. /1 оноо/

- A. Либерал онол
- B. Реалист онол
- C. Неореалист онол
- D. Неолиберал онол
- E. Марксист онол



54. Олон улсын байгууллагын үйл ажиллагааны цар хүрээний бүдүүвчийг гүйцээгээрэй.

/2 оноо/



- A. a-НАТО, b-НҮБ
- B. a-НҮБ, b-Ислам улсуудын чуулга уулзалт
- C. a-Исламын улсуудын чуулга уулзалт, b-Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн
- D. a-Олон улсын Гаалийн шүүх, b-ШХАБ
- E. a-АПЕК, b-Евразийн эдийн засгийн холбоо

55. Зөөлөн хүчний бодлогын үйлдлийн төрлийг сонгоно уу.

/1 оноо/

- A. Үнэт зүйлс, төрийн бодлого
- B. Эдийн засгийн хүч
- C. Захирах чадвар
- D. Удирдамж
- E. Сэтгэл татам байдал

56. Жозеф Самуэль Най, Роберт Коэхэнтэй хамтран 1977 онд олон улсын харилцааны неолиберал онолын чиглэлээр “хүч чадавх ба харилцан хамаарал” гэсэн бүтээлээ туурвисан. Энэхүү бүтээлд хамаарах үзэл санааг ялгаарай.

/2 оноо/

1. Клинтонь засаглалын үед түүний ухаалаг хүчний бодлогыг дэмжсэн
2. ОХУ-д зөөлөн хүчний бодлогыг дэвшүүлж, хүлээн зөвшөөрүүлсэн
3. Эдийн засгийн дипломат харилцааг тодорхойлж тайлбарласан
4. Гадаад худалдааны протекционист бодлогыг дэвшүүлсэн

- A. 1, 2
- B. 1, 3
- C. 2, 4
- D. 3, 4
- E. 2, 3

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай нийт 20 оноотой. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.**

2.1. ДНБ-ний үзүүлэлтийг тодорхойлолттой нь харгалзуулна уу.

/5 оноо/

a	Бодит ДНБ-г тооцох	1	Тухайн улсын хэмжээнд жилийн турш үйлдвэрлэсэн баялгийн орлогын нийлбэр дүн
b	Нэг хүнд ногдох ДНБ-ийн өсөлт	2	Хэрэглэгчдийн эцсийн хэрэглээндээ зориулан худалдан авахад зарцуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлбэр дүн
c	Бодит ДНБ-ийн өсөлт	3	Тухайн улсын улсын эдийн засгийн чадавхыг харуулдаг.
d	ДНБ-ийг зардлаар тооцох	4	Тухайн улсын иргэдийн амжиргааны түвшинг илтгэнэ.
e	ДНБ-ийг орлогоор тооцох	5	Тухайн жилийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн түвшний ерөнхий өсөлт буюу инфляцийн түвшинд харьцуулж тодорхойлно.



2.2. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.

/5 оноо/

a	Оролтод хамаарах шаардлага	1	Төрийн бодлогын тодорхой илрэл болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл, сурталчилгаа гэх мэт
b	Оролцооны дэмжлэг	2	Төрийн албан ёсны мэдээлэл, бэлгэдлийг хүндэтгэх
c	Бодит дэмжлэг	3	Тодорхой бодлого, шийдвэрийг дэмжиж буйгаа илэрхийлэх
d	Үйлдэл	4	Улс төрийн системийн дотроос эсвэл, түүнийг хүрээлэн байгаа экологи, эдийн засаг, соёл зэрэг янз бүрийн системүүдээс гарч буй тулгалтууд
e	Эргэх холбоо	5	Улс төрийн системд хувьсан өөрчлөгдөж буй орчинд зохицох, шинэчлэх, өөрийгөө хадгалах бололцоог олгодог.

2.3 Бүрэн тэтгэвэр тогтоолгох үндэс болон нийгмийн даатгалын сангаас олгодог тэтгэмжүүдийг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.

/5 оноо/

a	Бүрэн тэтгэвэр тогтоолгох үндэслэл	1	Нийгмийн даатгалын шимтгэлийг 3 болон түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн байх
b	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох нөхцөл	2	Нийгмийн даатгалын шимтгэлийг 20-оос доошгүй жил төлсөн 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй
c	Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж олгох нөхцөл	3	Нийгмийн даатгалын шимтгэлийг 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн байх
d	Оршуулгын тэтгэмж олгох нөхцөл	4	Нийгмийн даатгалын шимтгэлийг 12 сар төлсөн, сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн байх
e	Ажилгүйдлийн тэтгэмж олгох нөхцөл	5	Нийгмийн даатгалын шимтгэлийг 24 сараас доошгүй хугацаанд төлсөн, сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн байх

2.4. Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллага, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудыг харгалзуулна уу.

/5 оноо/

a	UNESCO	1	1957 онд Ромын гэрээгээр байгуулагдсан
b	ШХАБ	2	Шанхайн хамтын ажиллагааны байгууллага
c	Европын холбоо	3	НҮБ-ын “Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага”
d	АСЕМ	4	Нэгдсэн үндэсний байгууллагын “Хүүхдийн сан”
e	UNICEF	5	Ази-Европын уулзалт

